

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/174/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Утас: 327734 Аудитын менежер: Утас: 315558 Б энд С аудит ХХК-ийн захирал Утас: 99050268	Х.Түвшинбаяр Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Д.Отгонбаяр Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn Д.Заяажаргал Цахим хаяг: info@bcauditllc.com
---	--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 966
танай _____-ны № _____-г

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН
ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН ДАРГА
С.АРИУНБОЛД ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж, шалгагдагч байгууллагаас хараат бусаар ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 718.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн түргэн тусламжийн төв нь 2025 онд яаралтай тусламж үйлчилгээний 5 салбар 1 авто бааз, 399 эмнэлгийн мэргэжилтан, эрүүл мэндийн ажилтантайгаар Нийслэлийн 6 дүүргийн иргэдэд газар дээр нь болон эмнэлэг хүртэлх түргэн тусламжийн үйлчилгээг 24 цаг тасралтгүй үзүүлж хоногт дунджаар 1300-2100 дуудлагад 40-45 баг үйлчилгээ үзүүлсэн байна. Бусад эрүүл мэндийн байгууллагаас -40 градусаас +40 градусын орчинд иргэдэд тусламж үйлчилгээг байгаа байршилд нь очиж зориулалтын түргэн тусламжийн автомашин дотор хүргэдгээрээ онцлог юм.

Аудитын гол асуудал

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангийн орлогоор түргэн тусламжийн Хьюндай стариа маркийн 10 автомашиныг худалдан авч парк шинэчлэлт, авто баазын барилгад их засвар хийж, автомашины угаалгын хэсгийг шинээр байгуулсан байна. Ингэснээр иргэдэд хүрэх дуудлагын хүлээлт багасаж тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх боломж бүрдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 87.0 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тод руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u>	4	654,875,602.74	21,769,160.79
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		654,875,602.74	21,769,160.79
<u>АВЛАГА</u>	5	5,292,313,764.70	3,503,657,628.33
Төлбөртэй үйлчилгээний авлага		5,211,206,199.70	3,503,657,628.33
Бусад авлага		81,107,565.00	
<u>БАРАА МАТЕРИАЛ</u>	6	1,248,945,961.96	1,575,368,227.41
Түүхий эд материал		560,208,033.76	702,603,477.41
Эм боох материал		560,208,033.76	702,603,477.41
Хангамжийн материал		688,737,928.20	872,764,750.00
Бичиг хэрэг		11,470,630.00	9,701,970.00
Аж ахуйн материал		581,605,286.20	556,005,780.00
Сэлбэг хэрэгсэл		95,662,012.00	307,057,000.00
<u>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</u>			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		7,196,135,329.40	5,100,795,016.53
<u>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</u>			
<u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u>	7	13,259,951,791.83	16,376,953,660.69
<u>Биет хөрөнгө</u>		12,793,941,691.74	15,911,194,760.56
Барилга, байгууламж		8,912,463,853.50	10,747,221,973.00
Хуримтлагдсан элэгдэл		(989,619,582.72)	(1,206,177,467.82)
Авто- тээврийн хэрэгсэл		7,734,211,967.61	9,477,511,967.61
Хуримтлагдсан элэгдэл		(4,567,739,769.29)	(4,979,850,404.69)
Машин, тоног төхөөрөмж		3,577,152,139.40	4,105,979,814.72
Хуримтлагдсан элэгдэл		(2,088,253,848.53)	(2,409,958,241.23)
Тавилга, аж ахуйн эд хогшил		397,822,499.13	390,727,607.13
Хуримтлагдсан элэгдэл		(182,095,567.36)	(214,260,488.16)
<u>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</u>		466,010,100.09	465,758,900.13
Программ хангамж		44,713,500.00	44,713,500.00
Хуримтлагдсан элэгдэл		(44,022,699.91)	(44,273,899.87)
Бусад		465,319,300.00	465,319,300.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		13,259,951,791.83	16,376,953,660.69
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		20,456,087,121.23	21,477,748,677.22
Өглөг	9	1,335,984,467.19	1,896,506,576.71
Ажиллагчидтай холбогдсон өглөг		1,251,095,997.19	465,154,440.71
Бараа үйлчилгээний зардлын өглөг		84,888,470.00	231,235,034.00
Бусад өглөг			1,200,117,102.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		1,335,984,467.19	1,896,506,576.71
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		1,335,984,467.19	1,896,506,576.71
Засгийн газрын хувь оролцоо		19,120,102,654.04	19,581,242,100.51
Дахин үнэлгээний нэмэгдэл		3,272,089,880.77	3,270,295,964.32
Бусад цэвэр хөрөнгө/өмч		4,269,530,183.95	4,269,530,183.95
Хуримтлагдсан үр дүн		11,578,482,589.32	12,041,415,970.24
<u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u>		19,120,102,654.04	19,581,242,100.51
<u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</u>		20,456,087,121.23	21,477,748,677.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
<u>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>	21,007,078,368.00	20,831,907,304.00
Орон нутгийн төсвөөс	21,007,078,368.00	20,831,907,304.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,007,078,368.00	20,831,907,304.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,007,078,368.00	20,831,907,304.00
Бараа, үйлчилгээний орлого	882,388,716.73	713,539,864.96
Төсөвт байгууллагын өөрийн орлого	407,012,763.87	267,504,294.56
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,480,701.00	22,218,734.00
Туслах үйл ажиллагааны орлого	394,532,062.87	245,285,560.56
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	316,800,000.00	387,775,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	158,575,952.86	58,260,570.40
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	21,889,467,084.73	21,545,447,168.96
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
<u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>	15,657,454,581.99	16,214,830,935.33
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	13,883,814,730.51	14,371,618,567.83
Цалин	7,644,761,318.12	6,318,532,352.33
Цалингийн тусгай нэмэгдлүүд	5,094,461,600.86	5,546,012,534.71
Унаа хоолны хөнгөлөлт	590,716,779.00	1,220,099,849.68
Урамшуулал	553,875,032.53	1,286,973,831.11
Нийгмийн хамгааллын шимтгэл	1,773,639,851.48	1,843,212,367.50
Тэтгэврийн даатгал	1,177,970,395.47	1,236,205,062.43
Тэтгэмжийн даатгал	139,234,987.86	143,790,010.49
ҮОМШӨ-ний даатгал	125,590,647.96	118,760,106.87
Эрүүл мэндийн даатгал	264,940,312.46	275,767,169.49
Ажилгүйдлын даатгал	65,903,507.73	68,690,018.22
<u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u>	4,840,928,130.16	4,350,116,494.75
Тогтмол зардал	112,359,789.71	-
Гэрэл цахилгааны зардал	58,414,026.33	
Түлш, халаалтын зардал	32,111,937.23	
Цэвэр, бохир усны зардал	21,833,826.15	
Үйл ажиллагааны зардал	509,204,341.01	577,773,498.59
Хоол	-	11,068,772.00
Эм	509,204,341.01	566,704,726.59
Бусад бараа үйлчилгээний зардал	2,910,983,055.51	2,397,935,258.02
Бичиг хэргийн материал	27,064,038.00	33,020,090.00
Тээвэр, шатахууны зардал	1,068,900,468.00	1,129,037,810.40
Шуудан холбооны зардал	48,656,672.66	49,197,436.66
Хог хаягдал, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	173,568,266.95	177,762,204.00
БҮТЭЗ	7,555,362.00	2,216,000.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,095,000.00	2,280,000.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	16,881,305.00	

Бараа материал акталсны зардал	312,288,858.40	180,536,694.96
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	175,626,324.00	83,602,375.00
Даатгалын үйлчилгээ	77,000,000.00	68,765,238.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,800,000.00	7,600,000.00
Урсгал засварын зардал	982,092,650.50	634,589,807.00
Тээврийн хэрэгслийн татвар	9,475,910.00	26,929,602.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,978,200.00	2,398,000.00
Бусад зардал	1,308,380,943.93	1,374,407,738.14
Газрын төлбөр	2,491,893.00	2,489,297.00
Мэдээл, технологийн үйлчилгээ	5,300,000.00	20,283,340.00
Бараа үйлчилгээний бусад зардал	60,036,396.09	16,991,373.00
Элэгдлийн зардал	1,240,552,654.84	1,334,643,728.14
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	226,577,712.61	177,912,092.41
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	451,905,880.00	341,448,200.00
Урсгал шилжүүлэг	678,483,592.61	519,360,292.41
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	21,176,866,304.76	21,084,307,722.49
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	712,600,779.97	461,139,446.47
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	712,600,779.97	461,139,446.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
Татаас, санхүүжилтийн орлого	19,969,559,968.30	22,539,455,875.37
Нийгмийн даатгалын сангаас	19,969,559,968.30	22,539,455,875.37
Бараа, үйлчилгээний орлого	412,817,298.78	268,379,919.56
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,480,701.00	22,218,734.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,336,597.78	246,161,185.56
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	20,382,377,267.08	22,807,835,794.93
Ажиллагчидтай холбогдсон зардал	14,406,358,584.80	17,004,447,875.81
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	12,977,763,013.88	14,644,792,067.48
Цалин	4,813,782,337.25	6,591,705,851.98
Цалингийн тусгай нэмэгдлүүд	6,101,306,187.21	5,546,012,534.71
Унаа хоолны хөнгөлөлт	768,343,970.49	1,220,099,849.68
Урамшуулал	1,294,330,518.93	1,286,973,831.11
Нийгмийн хамгааллын шимтгэл	1,428,595,570.92	2,359,655,808.33
Тэтгэврийн даатгал	1,050,250,470.92	1,829,914,106.50
Тэтгэмжийн даатгал	94,586,100.00	131,832,341.76
ҮОМШӨ-ний даатгал	47,293,400.00	69,407,685.96
Ажилгүйдлийн даатгал	47,293,400.00	65,689,754.83
Эрүүл мэндийн даатгалын хураамж	189,172,200.00	262,811,919.28

Бараа ,үйлчилгээний урсгал зардал	4,691,630,116.18	3,653,848,431.07
Тогтмол зардал	112,359,789.71	
Гэрэл цахилгааны зардал	58,414,026.33	
Түлш, халаалтын зардал	32,111,937.23	
Цэвэр, бохир усны зардал	21,833,826.15	
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	374,530,180.00	682,013,452.00
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	374,530,180.00	672,732,680.00
Хоол, хүнс		9,280,772.00
Бусад бараа үйлчилгээний зардал	4,204,740,146.47	2,971,834,979.07
Бусад бараа үйлчилгээний зардал	57,016,089.00	19,937,073.00
Бичиг хэргийн материал	29,357,340.00	21,641,000.00
Тээвэр, шатахууны зардал	1,044,619,500.00	1,097,605,700.00
Шуудан холбооны зардал	48,656,672.66	49,197,436.66
Хог хаягдал зайлуулах, хортон устгал, ариутгал	17,122,440.00	34,970,100.00
БҮТЭЗ	205,490,132.00	152,458,506.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,095,000.00	2,280,000.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас авах зардал	217,188,300.00	
Маягт хэвлүүлэх зардал	5,092,753.00	2,302,780.00
Багаж техник хэрэгсэл	30,006,872.00	21,796,100.00
Урсгал засварын зардал	1,556,895,008.20	846,210,139.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190,576,324.00	99,882,375.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,800,000.00	7,600,000.00
Даатгалын үйлчилгээ	77,000,000.00	68,765,238.00
Тээврийн хэрэгслийн татвар	9,475,910.00	26,929,602.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,978,200.00	2,398,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,300,000.00	20,283,340.00
Газрын төлбөр	2,491,893.00	2,489,297.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	226,577,712.61	177,912,092.41
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	470,000,000.00	317,176,200.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	19,097,988,700.98	20,658,296,306.88
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,284,388,566.10	2,149,539,488.05
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	19,132,900.00	2,782,645,930.00
Тоног төхөөрөмж	613,000,000.00	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)	632,132,900.00	2,782,645,930.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	(632,132,900.00)	(2,782,645,930.00)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII) + (VIII)	652,255,666.10	(633,106,441.95)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,619,936.64	654,875,602.74
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	654,875,602.74	21,769,160.79

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	4,269,530,183.95	3,272,222,200.77	10,865,749,489.35	18,407,501,874.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			132,320.00	132,320.00
Залруулсан үлдэгдэл	4,269,530,183.95	3,272,222,200.77	10,865,881,809.35	18,407,634,194.07
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(132,320.00)		(132,320.00)
Тайлант үеийн үр дүн			712,600,779.97	712,600,779.97
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,269,530,183.95	3,272,089,880.77	11,578,482,589.32	19,120,102,654.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга			1,793,934.45	1,793,934.45
Залруулсан үлдэгдэл	4,269,530,183.95	3,272,089,880.77	11,580,276,523.77	19,121,896,588.49
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(1,793,934.45)		(1,793,934.45)
Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого				-
Тайлант үеийн үр дүн			461,139,446.47	461,139,446.47
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,269,530,183.95	3,270,295,946.32	12,041,415,970.24	19,581,242,100.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	24,717,575,300.00	22,539,455,875.37	2,178,119,424.63	91.2
Нийгмийн даатгалын сангаас	24,717,575,300.00	22,539,455,875.37	2,178,119,424.63	91.2
Бараа, үйлчилгээний орлого	1,022,746,900.00	268,379,919.56	754,366,980.44	26.2
Урьд оны үлдэгдлээс	654,875,600.00		654,875,600.00	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		22,218,734.00	(22,218,734.00)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	367,871,300.00	246,161,185.56	121,710,114.44	66.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	25,740,322,200.00	22,807,835,794.93	2,932,486,405.07	88.6
Ажиллагчидтай холбогдсон зардал	17,798,491,000.00	17,004,447,875.81	794,043,124.19	95.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	16,025,334,300.00	14,644,792,067.48	1,380,542,232.52	91.4
Цалин	8,529,132,100.00	6,591,705,851.98	1,937,426,248.02	77.3
Цалингийн тусгай нэмэгдлүүд	5,205,124,400.00	5,546,012,534.71	(340,888,134.71)	106.5
Унаа хоолны хөнгөлөлт	881,095,000.00	1,220,099,849.68	(339,004,849.68)	138.5
Урамшуулал	1,409,982,800.00	1,286,973,831.11	123,008,968.89	91.3
Нийгмийн хамгааллын шимтгэл	1,773,156,700.00	2,359,655,808.33	(586,499,108.33)	133.1
Тэтгэврийн даатгал	1,205,746,500.00	1,829,914,106.50	(624,167,606.50)	151.8
Тэтгэмжийн даатгал	141,852,500.00	131,832,341.76	10,020,158.24	92.9
ҮОМШӨ-ний даатгал	70,926,300.00	69,407,685.96	1,518,614.04	97.9
Ажилгүйдлийн даатгал	70,926,300.00	65,689,754.83	5,236,545.17	92.6
Эрүүл мэндийн даатгалын хураамж	283,705,100.00	262,811,919.28	20,893,180.72	92.6
Бараа, үйлчилгээний урсгал зардал	7,435,904,800.00	5,941,406,068.66	1,494,498,731.34	79.9
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	869,149,200.00	682,013,452.00	187,135,748.00	78.5
Хоол	5,811,400.00	9,280,772.00	(3,469,372.00)	159.7
Эм	863,337,800.00	672,732,680.00	190,605,120.00	77.9
Бусад бараа үйлчилгээний зардал	6,566,755,600.00	5,259,392,616.66	1,307,362,983.34	80.1
Бичиг хэргийн материал	15,000,000.00	21,641,000.00	(6,641,000.00)	144.3
Тээвэр, шатахууны зардал	1,124,824,900.00	1,097,605,700.00	27,219,200.00	97.6
Шуудан холбооны зардал	52,059,000.00	49,197,436.66	2,861,563.34	94.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	47,351,300.00	34,970,100.00	12,381,200.00	73.9
БҮТЭЗ	152,539,600.00	152,458,506.00	81,094.00	99.9
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,280,000.00	2,280,000.00	-	100.0

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Маягт хэвлүүлэх зардал	3,500,000.00	2,302,780.00	1,197,220.00	65.8
Багаж, техник хэрэгсэл	2,167,080,000.00	1,157,080,100.00	1,009,999,900.00	53.4
Урсгал засварын зардал	2,680,629,700.00	2,481,285,069.00	199,344,631.00	92.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	142,685,400.00	112,169,375.00	30,516,025.00	78.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,800,000.00	7,600,000.00	1,200,000.00	86.4
Даатгалын үйлчилгээ	69,000,000.00	68,765,238.00	234,762.00	99.7
Тээврийн хэрэгслийн татвар	35,500,000.00	26,929,602.00	8,570,398.00	75.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,540,600.00	2,398,000.00	1,142,600.00	67.7
Газрын төлбөр	5,000,000.00	2,489,297.00	2,510,703.00	49.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,028,000.00	20,283,340.00	16,744,660.00	54.8
Бараа үйлчилгээний бусад зардал	19,937,100.00	19,937,073.00	27.00	100.0
Урсгал шилжүүлэг	505,926,400.00	495,088,292.41	10,838,107.59	97.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	177,926,400.00	177,912,092.41	14,307.59	100.0
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	328,000,000.00	317,176,200.00	10,823,800.00	96.7
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	25,740,322,200.00	23,440,942,236.88	2,299,379,963.12	91.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,619,936.64	654,875,602.74		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	654,875,602.74	21,769,160.79		

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 6,918,754.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урьд оны ЭМДС-аас авах 5,211,206.2 мянган төгрөгийн авлагыг тайлант оны орлогоор бүртгэсэн, оны эцэст авлагаа тааруулахын тулд 1,707,548.6 мянган төгрөгийн ЭМДС-ийн орлого бууруулж бичилт хийсэн, нийт 6,918,754.8 мянган төгрөгийн алдааг залруулсан.	1	6,918,754.8					1	6,918,754.8				
Дүн	1	6,918,754.8					1	6,918,754.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 718,693.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 19,350.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 546,593.6 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 152,750.0 мянган төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах Албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Тоо	Дүн				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Батлагдсан төсвөөс бэлэг дурсгал худалдан авч, төсвийг үргүй зарцуулсан.	1	16,280.00	1	16,280.00								
Чанарын албаны дарга нь ЭМЯ-наас зарласан хөтөлбөрт тэнцэж, гадаадад сургалтанд явсан, байр хоолны мөнгийг байгууллагаас төлсөн боловч дэмжин	1	3,070.00	1	3,070.00								

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нотлох баримтгүй, мөн цалинг бүх нэмэгдэл урамшуулал, унаа, хоолны хөнгөлөлттэй давхардуулан бүтэн олгосон.										
Өмнөх жилийн ажлын үр дүнгийн урамшууллыг тухайн онд олгосон боловч тайлант оны 1 дүгээр сард дахин ажилласан хугацаанд нь оногдуулж, хуульд заагдаагүй нэмэгдэл урамшуулал давхардуулан олгосон байна.	1	231,205.8			1	231,205.8				
Захиргааны албан хаагчдад 2-4 удаа давхардуулан, шагнал урамшуулал, дэмжлэгийн мөнгийг нэг сая төгрөгнөөс 2 сарын цалинтай тэнцэх хэмжээгээр хавтгайруулан олгосон.	1	63,739.4			1	63,739.4				
Ажилчдын хоолыг 4 дүгээр сараас эхлэн гэрээт байгууллагаар хийлгэдэг болж тогооч нарыг цомхотгосон боловч хоолны технологичийг ажиллуулан цалин олгож үргүй зардал гаргасан байна.	1	9,364.4			1	9,364.4				
Бараа материалын дансанд их хэмжээний нөөц үүсгэсэн, өмнөх аудитын зөвлөмж хэрэгжээгүй	1	242,284.0			1	242,284.0				
Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй бараа материалыг жижиглэн худалдан авсан, өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	152,750.0						1	152,750.0	
Дүн	7	718,693.6	2	19,350.0	4	546,593.6			1	152,750.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитаар нийт 226,412.3 мянган төгрөгийн зөрчлөлд 1 албан шаардлага хүргүүлээ.

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Автомашин сэлбэг худалдан авах тендерийг 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр зарлаж, Идам төгс од ХХК шалгарч гэрээ байгуулсан. Тус компани нь 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Улсын бүртгэлийн газарт Автомашин сэлбэг худалдаа гэсэн үйл ажиллагааны чиглэл бүртгүүлсэн. Энэ нь тендерийн ерөнхий нөхцөл дээр заасан ижил төстэй ажил үйлчилгээг үзүүлдэг байх гэсэн нөхцлийг хангаагүй газрыг тендэрт шалгаруулсан байна.	1	226,412.3			1	226,412.3		
Дүн	1	226,412.3			1	226,412.3		